ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Идэр сумын Эрүүл мэндийн төв-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/97/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай хот

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn

Ахлах аудитор : Б.Дагвасүрэн

Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn

Аудитор П.Ганцолмон

Утас:70157405 Цахим хаяг:uliastaivanaudit@ubaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1. **Аудитын санал дүгнэлт** ........ 2

2. **Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

   2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4

   2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан ........ 5

   2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7

   2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 8

   2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10

3. **Аудитын тайлан**

   3.1 Ерөнхий зүйл ........ 12

   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 12

   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12

   3.4 Материаллаг байдал ........ 13

   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 13

   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 14

   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 14

   3.8 Аудитын гол асуудал ........ 14

   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, бусад хууль тогтоомж ........ 14

   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15

   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 15

4. **Аудитын илрүүлэлт** ........ 15


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2024.02.24 № 13Ө2/832
танай ______ -ны № ______ -т

ИДЭР СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ М.ОТГОНДОЛГОР-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Идэр сумын эрүүл мэндийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Идэр сумын эрүүл мэндиин 2021 оны 12 дугаар сарын 31-нии өдрөөрх санхүүгиин тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгиин тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

012025344

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
## 2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **29,326,837.00** | **140,290,693.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 298,996.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 298,996.00 |
| **3121** | **Төгрөг** | - | 298,996.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 298,996.00 |
| **33** | **АВЛАГА** | - | 83,230,000.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 83,230,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 29,326,837.00 | 56,761,697.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 9,328,969.00 | 24,740,480.00 |
| 35130 | Эм боох материал | 9,328,969.00 | 24,740,480.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 19,697,868.00 | 31,721,217.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 302,500.00 | 827,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,525,220.00 | 24,407,297.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,352,148.00 | 3,728,320.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,518,000.00 | 2,758,500.00 |
| 35600 | Мал амьтад | 300,000.00 | 300,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **439,538,153.17** | **526,875,368.97** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 439,538,153.17 | 526,875,368.97 |
| **392** | **Биет хөрөнгө** | 431,556,153.17 | 518,953,368.97 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 413,644,249.33 | 413,644,249.33 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (24,287,239.65) | (35,943,238.41) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 34,531,429.00 | 80,081,429.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (10,076,020.56) | (18,854,121.48) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 62,854,537.90 | 134,883,495.46 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (48,060,170.68) | (59,607,454.01) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 10,862,581.35 | 13,708,081.35 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (8,211,473.52) | (9,257,332.27) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,330,000.00 | 5,330,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (5,330,000.00) | (5,330,000.00) |
| 39217 | Ном | 298,260.00 | 298,260.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 7,982,000.00 | 7,922,000.00 |
| 39301 | Програм хангамж | 300,000.00 | 300,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (180,000.00) | (240,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,862,000.00 | 7,862,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **468,864,990.17** | **667,166,061.97** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **468,864,990.17** | **667,166,061.97** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 468,864,990.17 | 667,166,061.97 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 338,916,174.75 | 338,916,174.75 |
| 51101 | Өмч: - төрийн | 338,916,174.75 | 338,916,174.75 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 90,843,783.75 | 289,144,855.55 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 116,667,571.06 | 90,843,783.75 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (25,823,787.31) | 198,301,071.80 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 39,105,031.67 | 39,105,031.67 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **468,864,990.17** | **667,166,061.97** |

## 2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **408,870,269.65** | **786,763,758.56** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **373,460,769.65** | **668,124,258.56** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,514,949.65 | 153,089,018.56 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,514,949.65 | 153,089,018.56 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 3,514,949.65 | 153,089,018.56 |
| **122** | **Тусламжийн орлого** | 24,560,520.00 | 100,482,740.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 24,560,520.00 | 100,482,740.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 345,385,300.00 | 414,552,500.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 345,385,300.00 | 414,552,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **35,409,500.00** | **118,639,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 35,409,500.00 | 35,409,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 35,409,500.00 | 35,409,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | - | 83,230,000.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | - | 83,230,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **434,120,878.49** | **588,462,686.76** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **434,120,878.49** | **588,462,686.76** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 433,510,878.49 | 558,195,585.76 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 263,305,337.00 | 284,677,626.00 |
| 210101 | Үндсэн цалин | 177,778,217.00 | 173,999,014.00 |
| 210102 | Нэмэгдэл | 63,104,020.00 | 79,872,538.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,104,000.00 | 4,550,000.00 |
| 210104 | Урамшуулал | 17,319,100.00 | 26,256,074.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,615,032.00 | 37,305,436.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,845,224.00 | 26,277,208.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,633,050.00 | 2,955,976.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,303,341.00 | 2,277,419.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 567,309.00 | 526,801.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,266,108.00 | 5,268,032.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32,467,182.00 | 33,743,099.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,317,102.00 | 2,714,119.00 |
| 210302 | Түлш, халаалт | 30,992,480.00 | 30,972,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 157,600.00 | 56,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27,126,607.28 | 58,808,034.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,918,050.00 | 2,451,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,655,385.00 | 16,108,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,179,800.00 | 1,278,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 42,000.00 | 47,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 662,000.00 | 420,460.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,048,400.00 | 38,281,784.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,620,972.28 | 221,090.00 |
| **2105** | **Норматив зардал** | 39,329,297.35 | 79,782,449.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 33,463,735.35 | 69,064,921.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,865,562.00 | 10,717,528.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,762,300.00 | 7,493,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,762,300.00 | 7,493,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 341,900.00 | 350,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 341,900.00 | 350,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 348,000.00 | 320,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 210,000.00 | 210,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Дааталын үйлчилгээ | 70,000.00 | 70,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 68,000.00 | 40,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 34,215,222.86 | 55,714,741.76 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,003,393.00 | 22,627,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 25,211,829.86 | 33,087,241.76 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 610,000.00 | 30,267,101.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 30,164,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 30,164,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 610,000.00 | 103,101.00 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 610,000.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 103,101.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(25,250,608.84)** | **198,301,071.80** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 573,178.47 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 573,178.47 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (573,178.47) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(25,823,787.31)** | **198,301,071.80** |

## 2.3 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **338,916,174.75** | **39,105,031.67** | **116,667,571.06** | **494,688,777.48** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **338,916,174.75** | **39,105,031.67** | **116,667,571.06** | **494,688,777.48** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (25,823,787.31) | **(25,823,787.31)** |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **338,916,174.75** | **39,105,031.67** | **90,843,783.75** | **468,864,990.17** |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **338,916,174.75** | **39,105,031.67** | **90,843,783.75** | **468,864,990.17** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **338,916,174.75** | **39,105,031.67** | **90,843,783.75** | **468,864,990.17** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 198,301,071.80 | **198,301,071.80** |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **338,916,174.75** | **39,105,031.67** | **289,144,855.55** | **667,166,061.97** |

## 2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **405,355,320.00** | **550,444,740.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **369,945,820.00** | **515,035,240.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 24,560,520.00 | - |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | 24,560,520.00 | - |
| 122 | **Тусламжийн орлого** | - | 100,482,740.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | - | 100,482,740.00 |
| 123 | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 345,385,300.00 | 414,552,500.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 345,385,300.00 | 414,552,500.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **35,409,500.00** | **35,409,500.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсөвөөс** | 35,409,500.00 | 35,409,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 35,409,500.00 | 35,409,500.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **405,355,320.00** | **544,765,744.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **405,355,320.00** | **544,765,744.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **404,745,320.00** | **514,168,643.00** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 263,305,337.00 | 284,677,626.00 |
| 210101 | Үндсэн цалин | 177,778,217.00 | 173,999,014.00 |
| 210102 | Нэмэгдэл | 63,104,020.00 | 79,872,538.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,104,000.00 | 4,550,000.00 |
| 210104 | Урамшуулал | 17,319,100.00 | 26,256,074.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,615,032.00 | 37,305,436.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,162,932.00 | 25,928,636.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,613,000.00 | 2,844,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,090,400.00 | 2,275,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 522,600.00 | 568,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,226,100.00 | 5,688,400.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32,467,182.00 | 34,103,099.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,317,102.00 | 2,714,119.00 |
| 210302 | Түлш, халаалт | 30,992,480.00 | 31,332,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 157,600.00 | 56,500.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 18,611,935.00 | 28,256,160.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,142,550.00 | 2,525,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,655,385.00 | 15,748,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,179,800.00 | 1,278,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 42,000.00 | 47,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 662,000.00 | 798,960.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,930,200.00 | 7,857,900.00 |
| 2105 | **Норматив зардал** | 40,690,851.00 | 98,094,722.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 33,224,791.00 | 83,952,522.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,711,060.00 | 12,093,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,755,000.00 | 2,048,500.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,987,690.00 | 9,072,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 795,390.00 | 1,154,400.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 430,000.00 | 425,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,762,300.00 | 7,493,300.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 341,900.00 | 350,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 341,900.00 | 350,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 348,000.00 | 770,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 210,000.00 | 210,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 70,000.00 | 70,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 68,000.00 | 40,900.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | 450,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,377,393.00 | 21,538,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,377,393.00 | 21,538,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **610,000.00** | **30,597,101.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 30,494,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 30,494,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 610,000.00 | 103,101.00 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 610,000.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 103,101.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | - | **5,678,996.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | - | **5,380,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **5,380,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 5,380,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 5,380,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | - | **(5,380,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 298,996.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 298,996.00 |

## 2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Зөрүү** | **Хувь** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **429,503,000.00** | **421,022,053.00** | **8,480,947.00** | **98%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **429,503,000.00** | **421,022,053.00** | **8,480,947.00** | **98%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **429,166,000.00** | **420,692,053.00** | **8,473,947.00** | **98%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **288,817,900.00** | **282,968,264.00** | **5,849,636.00** | **98%** |
| 210101 | Үндсэн цалин | 184,695,400.00 | 173,999,014.00 | 10,696,386.00 | 94% |
| 210102 | Нэмэгдэл | 71,653,800.00 | 78,163,176.00 | (6,509,376.00) | 109% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,566,000.00 | 4,550,000.00 | 1,016,000.00 | 82% |
| 210104 | Урамшуулал | 26,902,700.00 | 26,256,074.00 | 646,626.00 | 98% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **38,991,300.00** | **37,305,436.00** | **1,685,864.00** | **96%** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,438,400.00 | 25,928,636.00 | 1,509,764.00 | 94% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,888,300.00 | 2,844,200.00 | 44,100.00 | 98% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,310,600.00 | 2,275,400.00 | 35,200.00 | 98% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 577,500.00 | 568,800.00 | 8,700.00 | 98% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,776,500.00 | 5,688,400.00 | 88,100.00 | 98% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **33,406,200.00** | **33,303,099.00** | **103,101.00** | **100%** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,276,100.00 | 1,914,119.00 | (638,019.00) | 150% |
| 210302 | Түлш, халаалт | 31,972,500.00 | 31,332,480.00 | 640,020.00 | 98% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 157,600.00 | 56,500.00 | 101,100.00 | 36% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **20,060,500.00** | **19,975,660.00** | **84,840.00** | **100%** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,525,600.00 | 2,525,600.00 | - | 100% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,908,200.00 | 12,908,200.00 | - | 100% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,190,000.00 | 1,118,500.00 | 71,500.00 | 94% |
| 210404 | Ном, хэвлэл | 60,000.00 | 47,000.00 | 13,000.00 | 78% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 799,300.00 | 798,960.00 | 340.00 | 100% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,577,400.00 | 2,577,400.00 | - | 100% |
| **2105** | **Нормативт зардал** | **33,478,600.00** | **33,438,594.00** | **40,006.00** | **100%** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 25,696,400.00 | 25,696,394.00 | 6.00 | 100% |
| 210502 | Хоол, хүнс | 5,733,700.00 | 5,693,700.00 | 40,000.00 | 99% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,048,500.00 | 2,048,500.00 | - | 100% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,587,900.00** | **3,582,700.00** | **5,200.00** | **100%** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,154,400.00 | 1,154,400.00 | - | 100% |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 430,200.00 | 425,000.00 | 5,200.00 | 99% |
| 210604 | Урсгал засвар | 2,003,300.00 | 2,003,300.00 | - | 100% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,013,400.00** | **350,000.00** | **663,400.00** | **35%** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,013,400.00 | 350,000.00 | 663,400.00 | 35% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **812,800.00** | **770,900.00** | **41,900.00** | **95%** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 210,000.00 | 210,000.00 | - | 100% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 70,000.00 | 70,000.00 | - | 100% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 68,000.00 | 40,900.00 | 27,100.00 | 60% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 14,800.00 | - | 14,800.00 | 0% |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 450,000.00 | 450,000.00 | - | 100% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **8,997,400.00** | **8,997,400.00** | **-** | **100%** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,997,400.00 | 8,997,400.00 | - | 100% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **337,000.00** | **330,000.00** | **7,000.00** | **98%** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **337,000.00** | **330,000.00** | **7,000.00** | **98%** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 337,000.00 | 330,000.00 | 7,000.00 | 98% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **60,830,500.00** | **53,896,650.00** | **6,933,850.00** | **89%** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **35,409,500.00** | **35,409,500.00** | **-** | **100%** |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 35,409,500.00 | 35,409,500.00 | - | 100% |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | **25,421,000.00** | **18,487,150.00** | **6,933,850.00** | **73%** |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 25,421,000.00 | 18,487,150.00 | 6,933,850.00 | 73% |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **402,097.00** | **(402,097.00)** | |

## 2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **129,020,590.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **129,020,590.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 98,856,590.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,709,362.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,709,362.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 800,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 800,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,280,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,840,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 160,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,280,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 64,656,128.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 58,256,128.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,400,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,870,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,380,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,490,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,540,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,540,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 30,164,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 30,164,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 30,164,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Идэр сумын Эрүүл мэндийн төв-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгуулагаас Идэр сумын Эрүүл мэндийн төвтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Идэр сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 19-ны өдрийн 03/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Идэр сумын Эрүүл мэндийн төв Хүн амд ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлснээр аймгийн хэмжээнд тэргүүлэгч байгууллага болох, иргэдэд чанартай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй, нотолгоонд үндэслэсэн, эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тусламж үйлчилгээг үзүүлэх,оношлогоо, эмчилгээнд орчин үеийн мэдээлэл, технологийг нэвтрүүлж, техник технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэн ажиллах, эмнэлгийн хөгжлийн түвшинг сайжруулах зорилготой байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Идэр сумын Эрүүл мэндийн төв нь Дотоод аудитын нэгж байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл

үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Өмнө Идэр сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг дахин тогтоож АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 3,000.0 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 786,763.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,867.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 70 хувиар буюу 3,00.0 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | - | 299.0 | 299.0 |
| Авлага | - | 83,230.0 | 83,230.0 |
| Бараа | 29,326.8 | 56,761.6 | 27,434.8 |
| Үндсэн хөрөнгө | 439,538.1 | 526,875.4 | 87,337.3 |
| **Нийт хөрөнгө** | **468,864.9** | **667,166.0** | **198,301.1** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 468,864.9 | 667,166.0 | 198,301.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө** | **468,864.9** | **667,166.0** | **198,301.1** |

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 299.0 мянган төгрөг байна.

Авлага дансны эцсийн үлдэгдэл 83,230.0 мянган төгрөгөөр өссөн нь ковидын зардал, татаас санхүүжилтын авлага болно.

Бараа материалын дансны үлдэгдэл 27,434.8 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материалын нөөц худалдан авалттай холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 144,316.9 мянган төгрөг, хандивын хөрөнгөөр 38,044.5 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус олж бэлтгэн, 154,705.5 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны 87,337.3 мянган төгрөгийн өсөлт нь тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил дансдууд нэмэгдсэнтэй холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 5,380.0 мянган төгрөг, хандивын хөрөнгөөр 115,044.4 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус олж бэлтгэсэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 198,301.1 мянган төгрөг болж өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 429,503.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 421,022.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 35,409.5 мянган төгрөгийн, тусгай зориулалтын сангаас 285,531.9 мянган төгрөгийн, хандиваар 100,482.7 мянган төгрөгийн,нийт 421,424.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 421,022.0 мянган төгрөгийг зарцуулж, 103.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Харилцах дансны үлдэгдэл 299.0 мянган төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар тусгай зориулалтын сангаас 129,020.59 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэн нэмэлт санхүүжилтийн орлогыг 100 хувь зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 147 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл 1, хугацаа болоогүй 5 мэдэээлэл байна.

Хугацаа хоцроосон 1 мэдээлэл нь 1-р сарын Төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл байна. Байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмж хүргүүлснийг биелүүлсэн байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**
Анхаарал татахуйц асуудал байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

ЭМ-ийн даатгалын сангийн санхүүжилтийн өглөг, авлагын зөрүү буцаан татах мөнгө 30,730.0 мянган төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт хүргүүлж байна.

**4.1 Залруулсан алдаа**

**4.2 Төлбөрийн акт:** ЭМ-ийн даатгалын сангийн санхүүжилтийн өглөг, авлагын зөрүү буцаан татах мөнгө 30,730.0 мянган төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт хүргүүлж байна.

**4.3 Албан шаардлага өгөгдөөгүй.**

**4.4 Зөвлөмж өгөгдөөгүй.**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Идэр сумын ЭМТ | 1 | 30,730.0 | - | - | 1 | 30,730.0 | - | - | - | - |